

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТАГТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН /2019-2020 ОН/

АУДИТЫН КОД: ЗАА-2021/84-ШТА-ГА

Улиастай сум 2021 он



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Г.Хашцэцэг
Утас: 7046-3783, Цахим хаяг: khashtsetsegg@audit.gov.mn
Аудитор Г.Чулуунбаатар
Утас: 9908-4581, Цахим хаяг: chuluunbaatar@audit.gov.mn
Аудитор Ц.Оюунсүвд
Утас: 9907-6038, Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар, график, схем болон хүснэгтэн мэдээллийн жагсаалт.....	3
Аудитын зорилго, хамарсан хүрээ, шалгуур үзүүлэлт, стандарт, арга зүй, үндсэн мэдээлэл.....	4-6
БҮЛЭГ 1. ОРОН НУТГААС ОЛГОЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ОЛГОЛТЫН БАЙДАЛ, ХУУЛИЙН ХҮРЭЭНД ОНОВЧТОЙ ЭСЭХ	
1.1. Тусгай зөвшөөрлийг олгохдоо хууль журамд заасан норматив, байршлыг мөрдөж ажилласан байна уу.....	7-11
1.2. Тусгай зөвшөөрлийг шаардлага хангасан аж ахуйн нэгж иргэдэд олгож байна уу	12-18
БҮЛЭГ 2. ОРОН НУТГААС ОЛГОЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ТАВИХ ХЯНАЛТ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ЭСЭХ	
2.1. Тусгай зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгж хууль журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна уу.....	19-21
2.2. Тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллагууд хууль журмын дагуу ажилласан байна уу.....	22-24
2.3. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна уу.....	24
АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТ	25-28
ЗӨВЛӨМЖ	29-31
ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН АЛБАН ТООТ	32-35
АУДИТ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ	36
ХАВСРАЛТУУД	37-45

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ШТА	Шууд тайлагнах ажил
ГА	Гүйцэтгэлийн аудит
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМГ	Эрүүл мэндийн газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХЭЗХ	Хууль, эрх зүйн хэлтэс
ЭМЧМҮАЭ	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ХЖДҮХ	Хүнс, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн

ГРАФИК, СХЕМ БОЛОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ-1	Тусгай зөвшөөрөл олгохдоо баримталж байгаа чиглэл, норм, норматив, байршлын танилцуулга
ХҮСНЭГТ-2	2019, 2020 онд эрүүл мэндийн чиглэлээр олгосон тусгай зөвшөөрлийг тэргүүлэх чиглэл болон орон нутгийн хэрэгцээ шаардлагатай харьцуулсан судалгаа
ХҮСНЭГТ-3	Тусгай зөвшөөрөл шинээр олгосон, сунгалт хийсэн байгууллагын тоо
СХЕМ-1	Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж, тусгай зөвшөөрлийн хугацааг тогтоосон эрх зүйн актууд
ГРАФИК-1	ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөлтэй байгууллагын судалгаа
ГРАФИК-2	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олголт, норматив харьцуулалт /сумдаар/
ГРАФИК-3	Түүвэрт хамрагдсан байгууллагын судалгаа

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/15 дугаар тушаал, байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд байгууллагын санаачилгаар хийж, гүйцэтгэлээ.

Аудитын зорилго:

Орон нутгаас олгож буй тусгай зөвшөөрөл олголт болон түүнд тавих хяналт хууль журмын дагуу хийгдэж байгаа эсэхэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ.

- *Орон нутгаас олгож буй тусгай зөвшөөрлийн олголтын байдал, хуулийн хүрээнд оновчтой эсэх*
- *Орон нутгаас олгож буй тусгай зөвшөөрөлд тавих хяналт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх*

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс, аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, аймгийн Татварын хэлтэс, 24 сумын Засаг дарга болон аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймаг, сумдад олгогдож буй тусгай зөвшөөрөлтэй холбоотой ажлын төлөвлөгөө, тайлан, захирамж, тооцоо, судалгаа болон шаардлагатай бусад баримт материалыг хамрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Засгийн газрын 2017.02.01-ний өдрийн 46 дугаар тогтоол “Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай”, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 59, 2012 оны 06, 2014 оны 18, 2017 оны 54 дүгээр тогтоол, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2018 оны 43 дугаар тогтоол, холбогдох бусад дүрэм, журам, хууль эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болголоо.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн аудитын стандарт, гүйцэтгэлийн аудитын зарчим (MNS 6817-5:2020), гүйцэтгэлийн аудит (MNS 6817-7:2020), гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудитын заавар аргачлалыг ашиглаж, шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан байгууллага, ажлын хэсгийн ажилтнуудаас асуулга, лавлагаа авах, ажлын төлөвлөгөө болон ажлын тайлан, бусад шаардлагатай баримт материалд

тулгуурлан дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйлийг цуглууллаа.

Төрийн аудитын стандарт, төрийн аудитын байгууллагаас аудит хийх журамд заасны дагуу аудитын явцад цуглуулсан болон боловсруулсан баримт бичгийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хянан удирдаж, аудитын менежер Г.Хашцэцэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, аудитор Г.Чулуунбаатар, аудитор Ц.Оюунсүвд нар 2021 оны 09 сарын 01-ний өдрөөс 2021 оны 11 сарын 10-ны хооронд гүйцэтгэлээ.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайлангийн нэгдүгээр бүлэгт орон нутгаас олгож байгаа тусгай зөвшөөрлийг хууль, журмын дагуу олгож байгаа эсэх, хоёрдугаар бүлэгт орон нутгаас олгогдсон тусгай зөвшөөрөлд тавих хяналт хууль, журмын дагуу хийгдэж байгаа эсэх талаар тусгаж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл

Аудитыг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2021 оны 09 сарын 01-ний өдрөөс эхэлсэн хэдий ч “Ковид-19” цар тахал дотоодод тархсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/327, Улиастай сумын Засаг даргын 2021 оны А/219 дүгээр захирамжуудаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгаснаар аудитад хамрагдагч байгууллагуудтай харилцах, холбогдох баримт материалыг татан авах, объект дээр ажиллахад хүндрэлтэй байлаа.

Мөн аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн хүнс, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарын бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн өндөр насны тэтгэвэрт гарч ажлаас чөлөөлөгдсөн, мэргэжилтний ажлыг давхар хариуцаж байгаа хөдөө, аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн болон сумдын холбогдох албан тушаалтнууд “Ковид-19” өвчнөөр эмнэлэгт хэвтсэн, Ковидын дараах гэрийн тусгаарлалт, “Ковид-19” өвчний ойрын хавьтал, ээлжийн амралтаа авсан зэргээс шалтгаалан албан тоотын хариу, тодруулга авах боломжгүй, цаг хугацааны хувьд хүлээлт үүсэж байлаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар аймгийн Засаг дарга дараах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгодог байна. Үүнд:

- *Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх;*
- *Сургалтын үйл ажиллагаа эрхлэх;*
- *Соётууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;*
- *Эмчилгээний гоо заслын үйлчилгээ;*
- *Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах;*

Харин сумын Засаг дарга дараах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгож байна. Үүнд:

- Агаарт бохирдуулах бодис гаргадаг физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглах;
- Тамхи худалдах;

Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй 29 ерөнхий боловсролын сургууль, 41 хүүхдийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 3 цэцэрлэг нь хувийн, 29 сургууль, 38 цэцэрлэг орон нутгийн төсвийн байгууллага байна. *График-1*



Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 97 байгууллага байгаа бөгөөд үүнээс анхан шатлалын эмнэлэг 22 буюу 22.7 хувь, хоёр дахь шатлалын эмнэлэг 8 буюу 8.2 хувь, хувийн эмнэлэг 14 буюу 14.4 хувь, эмийн эргэлтийн сан 21 буюу 21.6 хувь, эм ханган нийлүүлэх төв 3 буюу 3.1 хувь, хувийн эмийн сан 25 буюу 25.8 хувь, үлдсэн 4 буюу 4.2 хувийг шүдний протез, ахуйн шавж, мэрэгч хорхойн ариутгал халдваргүйтгэлийн үйлчилгээ эзэлдэг байна.

Аймаг, сумын хэмжээнд 2020 оны байдлаар согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй 276, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 40, нийт 316 аж ахуйн нэгж байгууллага байна. Харин тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй 144 иргэн, аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал хайх болон ашиглах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллага байхгүй байна.

**БҮЛЭГ 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ОЛГООГҮЙГЭЭС
ОРОН НУТГИЙН ОРЛОГОД 3.3 САЯ ТӨГРӨГИЙН ОРЛОГО ДУТУУ ТӨВЛӨРСӨН
БАЙНА.**

**1.1 Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах нормативыг тогтоосон хууль
эрх зүйн орчин хангалтгүй байна.**

Аймгийн Засаг дарга тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн 4 төрөлд, сумын Засаг дарга 1 төрөлд тусгай зөвшөөрөл олгож байна.

ЭМЧМҮА эрхлэх, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах тусгай зөвшөөрлүүдийг олгоход мөрдөх чиглэл, норматив байршлыг хууль, журам, сайдын тушаалаар баталж, харин бусад тусгай зөвшөөрлийн хувьд тогтоосон норматив байхгүй зах зээлийн эрэлт хэрэгцээ, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтэд тулгуурлан олгож байна.

Тусгай зөвшөөрөл олгохдоо баримталж байгаа чиглэл, норм, норматив, байршлын танилцуулгыг хүснэгт №1-ээр харуулав.

Хүснэгт № 1

№	Аж ахуйн үйл ажиллагааны төрөл	Мөрдөж ажиллах хууль журам	Мөрдөж ажиллах норматив
Аймгийн Засаг даргын захирамжаар зөвшөөрөл олгох аж ахуйн үйл ажиллагааны төрөл			
1	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх	ЭМС-ын 2015 оны 298 дугаар тушаалаар батлагдсан журам	ЭМЧМҮА эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийг 2 жил тутам шинэчлэн боловсруулна
2	Сургалтын үйл ажиллагаа эрхлэх	Боловсролын тухай хууль	Тогтоосон норматив байхгүй суралцагчийн эрэлт хэрэгцээнд тулгуурладаг
3	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх	Үйлдвэр, худалдааны сайдын - 2005 оны 110 дугаар тушаал - 2008 оны 05 дугаар тушаал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын -2020 оны А-272 дугаар тушаал	- 1,000 хүн ам тутамд 2-оос хэтрэхгүй байх - Нийслэл, аймгийн төвд 2,000 хүн ам тутамд 1-ээс хэтрэхгүй, сумын төвд согтууруулах ундаа худалдах цэг 1, согтууруулах ундаагаар үйлчлэх цэг 1 байх. -Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, нийслэл, суманд 1,000 хүн ам тутамд 4 хүртэл байх
4	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах
Сумын Засаг даргын захирамжаар тусгай зөвшөөрөл олгох аж ахуйн үйл ажиллагааны төрөл			
5	Тамхи худалдах	Тамхины хяналтын тухай хууль	Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрээс хол зайд орших цэгт

Аудитаар аймаг, сумын Засаг дарга аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгохдоо хууль, журамд заасан норм, норматив байршлыг мөрдөж ажилласан эсэх талаар шалгахад хэрэгжилт хангалтгүй үзүүлэлттэй байна. Үүнд:



7 сумын 76 цэгт
нормативаас илүү
зөвшөөрөл олгосон байна

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4¹-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А-272 дугаар тушаалаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, нийслэл, суманд 1,000 хүн ам тутамд 4 хүртэл байхаар шинэчлэн тогтоож, урьд мөрдөж байсан Үйлдвэр худалдааны сайдын 2005 оны 110, 2008 оны 05 дугаар тушаалуудыг хүчингүй болгожээ.

Манай аймгийн хувьд 2020 оны жилийн эцсийн бүртгэлтэй хүн ам 73,088 бөгөөд ХХААХҮС-ын 2020 оны А-272 дугаар тушаалаар баталсан нормативаар нийт 293 цэг байхаас согтууруулах ундаа худалдах 276, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 40, нийт 316 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Норматив хангаж байгаа эсэхийг сумдаар харьцуулахад: Алдархаан, Асгат, Баянтэс, Баянхайрхан, Дөрвөлжин, Идэр, Их-Уул, Нөмрөг, Сантмаргаз, Түдэвтэй, Тэлмэн, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй, Эрдэнэхайрхан, Яруу сумд нормативд хэмжээнд, харин 7 суманд нормативаас 76 цэгт илүү зөвшөөрөл олгосон бөгөөд Тосонцэнгэл, Улиастай сумдад нормативаас 67 цэгт илүү зөвшөөрөл олгосон байна.

График 2



6.4¹ Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаарх нормативыг тухайн орон нутгийн хүн амын тоо, үйлчилгээний хүрээ, эрүүл мэнд, соёлын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байрны байршлыг харгалзан худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

Завханмандал, Отгон, Сонгино, Тосонцэнгэл, Тэс, Улиастай, Ургамал сумдад согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо байвал зохих хэмжээнээс илүү байгаа нь тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтнууд ажилдаа хариуцлагагүй хандаж, мөрдөж байгаа нормативыг хэтрүүлж, хавтгайруулан олгосноос шалтгаалжээ.

Иймд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4² дэх заалтыг хэрэгжүүлж, ХХААХҮС-ын 2020 оны А-272 дугаар тушаалын 1 дэх заалтыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Мөн аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих” журамд өөрчлөлт оруулж, тусгай зөвшөөрөл хүсэгчийн хүсэлтийг, эрх бүхий байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсгээр хэлэлцэн, сонгон шалгаруулалтаар, тогтоосон нормативд багтаан олгох асуудлыг тусгаж өгөх шаардлагатай байна.



ИТХ-ын хайгуулын
болон уурхайн талбайг
тусгаагүй байна

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1³-д аймгийн ИТХ нь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгаж өгөхөөр заасан байна.

Аудитын явцад аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс тодруулахад “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлахад түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн уурхайн талбай байхгүй байсан” гэсэн тайлбарыг ирүүлсэн бөгөөд дээрх хуулийн заалт хэрэгжээгүй байна.

Иймд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах талаар судалж, төлөвлөгөөнд оруулах шаардлагатай байна.



Улиастай сумаас бусад сумд
500 метрийн доторх зайг
тодорхойлсон зураглалыг
баримтжуулаагүй байна

Сумын Засаг дарга Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14⁴ дэх заалтыг баримтлан тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгож байгаа боловч хэмжилтийг хийж баримтжуулаагүй байна. Энэ нь ЗГ-ын 2013 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих” журмын 5 дугаар зүйлийн 5.1.4⁵ дэх заалтыг зөрчиж байна. Иймд тамхины тусгай зөвшөөрөл олгосон аж ахуй нэгж байгууллага, иргэдийн тамхины цэгүүдийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн доторх зайг тодорхойлсон зураглалыг гаргаж баримтжуулан, нотлох баримтыг эргэн танилцуулах талаар зөвлөмж өглөө.

7.4³ Эрх бүхий байгууллага шаардлагатай гэж үзвэл сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгож болно.

11.1.1³ аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах;

6.7.14⁴ ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор тамхи худалдах

5.1.4⁵ ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн доторх зайг тодорхойлсон зураглалыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраар баталгаажуулсан баримт гаргуулсан байх;



Орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн 8 эмнэлэг, 1 ариутгалын үйлчилгээ, 6 эмийн санд шинээр тусгай зөвшөөрөл олгосон байна.

Аудитаар эрүүл мэндийн чиглэлээр шинээр олгосон тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны чиглэлийг ЭМС-ын 2018 оны А/421 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2018-2020 онд баримтлах тэргүүлэх чиглэл”-тэй уялдуулан олгосон эсэхийг авч үзлээ.

Аймгийн ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн комисс нь 2019, 2020 онд 15 байгууллагад шинээр тусгай зөвшөөрөл олгож, тус байгууллагуудын эрхлэх үйл ажиллагаа нь ЭМС-ын баталсан ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгоход баримтлах тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.

**2019, 2020 онд эрүүл мэндийн чиглэлээр олгосон тусгай зөвшөөрлийг
тэргүүлэх чиглэл болон орон нутгийн хэрэгцээ шаардлагатай
харьцуулсан судалгаа**

Хүснэгт № 2

№	Шинээр тусгай зөвшөөрөл олгосон байгууллага, үйл ажиллагааны чиглэл	2018-2020 онд баримтлах чиглэлтэй уялдсан эсэх	Тусгай зөвшөөрөл олгосон хугацаа	Орон нутгийн хэрэгцээ шаардлагатай уялдсан эсэх
Шинээр тусгай зөвшөөрөл олгосон хувийн эмнэлэг				
1	“Жавцаг мед” үүдэн эмнэлэг /Дотор, зүрх судасны оношилгоо/	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2019 он	Аймгийн төвд хэрэгцээ шаардлагатай.
2	“Гэгээн тус” үүдэн эмнэлэг /Уян дурангийн оношилгоо/	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2019 он	Аймгийн төвд хэрэгцээ шаардлагатай.
3	Сонгино сумын “Сант марал” үүдэн эмнэлэг /эхо оношилгоо/	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2019 он	Тухайн орон нутагт давхардалгүй, хэрэгцээ, шаардлагатай
4	Тосонцэнгэл сумын “Наран очир хайрхан” эмнэлэг /Дотор, элэг, цес, чих, хамар, хоолой, хүүхэд, БЗДХ-ын оношилгоо, эмчилгээ/	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2019 он	Тухайн орон нутагт хэрэгцээ шаардлагатай
5	“Төгс жаргалан” үүдэн эмнэлэг /Эхо оношилгоо/	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2019 он	Аймгийн төвд хэрэгцээ шаардлагатай.
6	“Баясгаланг хурахуй” шүдний эмнэлэг	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2019 он	Аймгийн төвд хэрэгцээ шаардлагатай.
7	“Гоо энэрэл” эмэгтэйчүүдийн эмнэлэг	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2020 он	Аймгийн төвд хэрэгцээ шаардлагатай.
8	“Хепа мед” үүдэн эмнэлэг /хоол боловсруулах эрхтэн, элэгний эмгэгийн урьдчилан сэргийлэлт оношилгоо, эмчилгээ/	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2020 он	Аймгийн төвд хэрэгцээ шаардлагатай.
Шинээр тусгай зөвшөөрөл олгосон эмийн сан болон бусад байгууллага				
9	“ЦЭ СО ББ” ХХК /Ахуй шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ/	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2019 он	Аймгийн төвд хэрэгцээ шаардлагатай.
10	Их-Уул сумын “Элбэг” эмийн сан	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2019 он	Тухайн орон нутагт давхардалгүй, хэрэгцээ,

**ОРОН НУТАГТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

		чиглэлд орсон		шаардлагатай
11	Отгон сумын “Эх тунамал” эмийн сан	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2019 он	Тухайн орон нутагт давхардалгүй, хэрэгцээ, шаардлагатай
12	“Монос” ХК-ийн салбар эмийн сан	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2019 он	Аймгийн төвд хэрэгцээ шаардлагатай.
13	Сонгино сумын “Сонгино Чандмань” эмийн сан	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2020 он	Тухайн орон нутагт давхардалгүй, хэрэгцээ, шаардлагатай
14	Нөмрөг сумын “Хонгийн толгой” эмийн сан	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2020 он	Тухайн орон нутагт давхардалгүй, хэрэгцээ, шаардлагатай
15	Тосонцэнгэл сумын “Чацаргана” эмийн сан	Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлд орсон	2020 он	Тухайн орон нутагт хэрэгцээ шаардлагатай.

ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн комисс нь журмын 2.1.3⁶-т заасны дагуу орон нутгийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ, шаардлагын судалгаа гаргаж, саналаа боловсруулан холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлдэггүй, 2.6.1⁷-д заасны дагуу эрүүл мэнд, эм хангамжийн байгууллага шинээр байгуулах төсөл тэргүүлэх чиглэл, тусламж үйлчилгээний бодит хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг хэлэлцдэггүй, хурлын тэмдэглэлд тодорхой тусгаагүй байна.

Иймд аймгийн ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн комисс аймгийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ, шаардлагын нэгдсэн судалгааг гарган, журмын 1.3⁸-т заасны дагуу ажиллаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хөдөө алслагдсан байршилд тусламж үйлчилгээг иргэдэд ойртуулах аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрлийг олгоход анхаарч ажиллах нь зүйтэй байна.

2.1.3⁶ Үйлчлэх хүрээний хун амын эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагыг судалж цаашид баримтлах тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, саналаа Эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх ажлын албанд хүргүүлэх;

2.6.1⁷ Тусгай зөвшөөрөл хүсэгчийн шинээр байгуулах эрүүл мэнд, эм хангамжийн; байгууллагын төсөлд Эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн захиргааны төв байгууллагаас баримталж буй ч тэргүүлэх чиглэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодит хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлж, албан ёсны хариуг өгөх, Шинжээч томилох эсэхийг шийдэх, шинжээч томилно.


1.3⁸ Комисс нь уйл ажиллагаандаа Аж ахуйн уйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлээр тогтоосон зарчмаас гадна дор дурдсан зарчмыг баримтална.

- Хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ, шаардлага
- Эрүүл мэндийн салбарт баримталж буй тэргүүлэх чиглэлийг үндэслэх;
- Тусламж, үйлчилгээ үзүүлэгчдээс зохиомлоор үүсгэх эрүүл мэндийн хэрэгцээ, санхүүгийн эрсдэлээс иргэдийг хамгаалах;
- Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай, нээлттэй байдлыг хангах;
- Ашиг сонирхлын зөрчилгүй байх;

1.2 Хууль, журамд заасан баримтын бүрдэл хангаагүй, тэмдэгтийн хураамж төлөөгүй, дутуу төлсөн аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд тусгай зөвшөөрлийг олгосон байна.

Аймаг, сумын Засаг даргаас олгох тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн хэмжээг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3⁹-д зааснаар, тусгай зөвшөөрлийн хугацааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1¹⁰, 6.2¹¹-т зааснаар дараах эрх зүйн актуудаар тус тус тогтоосон байна.

Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж, тусгай зөвшөөрлийн хугацааг тогтоосон эрх зүйн актууд /схем-1/



Аймгийн Засаг даргын захирамжаар олгох 5 төрлийн тусгай зөвшөөрлөөс 2019, 2020 онд 4 төрлийн тусгай зөвшөөрлийг 106 байгууллагад шинээр олгож, 247 байгууллагын хугацааг сунгасан байна.

Харин сумдын Засаг даргын захирамжаар олгох 2 төрлийн тусгай зөвшөөрлөөс 2019, 2020 онд зөвхөн тамхи худалдах тусгай зөвшөөрлийг 38 цэгт шинээр олгож, 82 цэгт хугацааг сунгасан байна. /Хүснэгт №3/

6.3⁹ Энэ хуулийн 35.1.4-35.1.22 дахь заалт, 35.2-35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно

6.1¹⁰ Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно.

6.2¹¹ Тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгаж болно.

Тусгай зөвшөөрөл шинээр олгосон, сунгалт хийсэн байгууллагын тоо

№	Нэр төрөл	2019 он		2020 он	
		Шинэ	Сунгалт	Шинэ	Сунгалт
1	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх	20	32	68	198
2	ЭМЧМҮА эрхлэх	10	17	5	-
3	Сургалтын үйл ажиллагаа эрхлэх	1	-	2	-
4	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах	-	-	-	-
5	Тамхи худалдах	20	40	18	42
Нийт дүн		51	89	93	240

Аудитын явцад согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж бүрэн төвлөрсөн эсэхийг шалгахад 1 ААНБ-аас тэмдэгтийн хураамж аваагүй байна.

Иймд аймгийн ИТХ-ын 2011 оны 59, 2014 оны 18, 2017 оны 54 дүгээр тогтоолоор тогтоосон тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээ болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь заалтын дагуу тэмдэгтийн хураамжийг тооцож, төвлөрүүлэх шаардлагатай байна.



ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгох үйл явц удаашралтай байна.

Аймгийн ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн комиссыг Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 298 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ын 1.5¹², 1.6¹³ дахь заалтын дагуу аймгийн Засаг даргын 2019 оны А/204 дүгээр захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2019 онд тусгай зөвшөөрөл хүсэж, төсөл, холбогдох материалаа ирүүлсэн 6 хувийн эмнэлэг, 4 эмийн сан, 1 ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал халдваргүйтгэлийн үйлчилгээнд шинээр тусгай зөвшөөрөл олгож, 3 хувийн эмнэлэг, 3 улсын эмнэлэг, 3 эмийн сан, 8 эмийн эргэлтийн сангийн тусгай зөвшөөрлийг сунгаж, 2 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг цуцалж, 2 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 2 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг сэргээсэн байна. 2020 онд аймгийн Засаг даргын 2020 оны А/301 дүгээр захирамжаар ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгох комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, тусгай зөвшөөрөл хүсэж, төсөл, холбогдох материалаа ирүүлсэн 2 хувийн эмнэлэг, 2 эмийн санд шинээр тусгай зөвшөөрөл олгож, 1 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг сэргээж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар хүсэлтээ ирүүлсэн 6 улсын эмнэлэг, 3 эмийн сан, 3 хувийн эмнэлгийн тусгай зөвшөөрлийг дахин олгож, 1 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн комисс нь журмын 4.2¹⁴, 4.3.2¹⁵ дахь заалтын дагуу орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр 2 жил хүртэл хугацаатай томилон, гэрээ байгуулан ажиллуулах бөгөөд шинжээчийн багийг тусгай зөвшөөрлийн комиссын 2018 оны 02 сарын 01-ний өдрийн

хурлаар хэлэлцэж, аймгийн Засаг даргын 2018 оны А/58 дугаар захирамжаар 3 хүний бүрэлдэхүүнтэй томилсон боловч байгуулсан гэрээ байхгүй, шинжээчийн багийг томилсноос хойш 3 жил гаруйн хугацаа өнгөрсөн ч одоог хүртэл өөрчлөөгүй байна. Энэ нь “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ын 1.7¹⁶ дахь заалтыг зөрчиж байна.

Мөн тусгай зөвшөөрлийн ажлын алба нь журмын 3.1.17¹⁷-д заасны дагуу “тусгай зөвшөөрөл хүсэгчийн ирүүлсэн хүсэлт болон төслийг хүлээн авч баримт бичгийн бүрдүүлэлтийг хянан, шаардлага хангаагүй баримт бичигт дахин тодруулга хийлгэн хүлээн авах”, 3.1.2¹⁸-т заасны дагуу “тусгай зөвшөөрөл хүсэгчийн шаардлага хангасан төслийг шинжээчийн дүгнэлтийн хамт комиссын хурлаар хэлэлцүүлэх” үүрэгтэй, шинжээчийн баг нь журмын 4.1.1¹⁹-д “тусгай зөвшөөрөл хүсэгчийн шинээр байгуулах эрүүл мэндийн байгууллагын төсөл бөгөөд тусгай зөвшөөрөл хүсэгчийн ирүүлсэн төсөл, бүрдүүлсэн баримт бичигтэй танилцаж санал гаргах”, 4.1.2²⁰-т “тусгай зөвшөөрөл хүсэгчийн ажлын байранд хяналт үнэлгээ хийж, дүгнэлтийг үнэн зөв гаргах” үүрэгтэй бөгөөд тусгай зөвшөөрөл хүсэгчийн бүрдүүлсэн баримт бичиг, хувийн хэргийн бүрдлийг шалгахад 2019 онд зарим байгууллага материалаа дутуу бүрдүүлсэн, ирүүлсэн материал шаардлага хангахгүй, эмх цэгцгүй байна. Тусгай зөвшөөрлийн ажлын алба, шинжээчийн баг баримт бичгийн бүрдүүлэлт, эмх цэгц, бүрдлийг хангуулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аудитаар Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төв, Түдэвтэй сум дундын эмнэлэг, Шилүүстэй сумын сум дундын эмнэлэг, Сонгино сумын Эрүүл мэндийн төв, Отгон сумын Эрүүл мэндийн төв, Ургамал сумын Эрүүл мэндийн төв, “Гоо энэрэл”, “Сонгино Сант марал” хувийн эмнэлэг, Их-Уул сумын “Гурван-Эрдэнэ” эмийн сан, Нөмрөг сумын “Хонгийн толгой” эмийн сан зэрэг байгууллагуудын Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх үйл ажиллагааны чиглэл, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ дээрх үйл ажиллагааны чиглэл таарахгүй, “Сонгино Чандмана” эмийн сан, “ЦЭ СО ББ” ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ, “Гурван-Эрдэнэ” эмийн сангийн үүсгэн байгуулагч, захирал, эрхлэгч нь мэргэжлийн хүн биш, Сонгино сумын “Сонгино Чандмана” эмийн сан, Тэлмэн сумын “Өвөгдий” эмийн сангуудад шинжээчийн баг ажиллуулалгүй тусгай зөвшөөрөл олгох дүгнэлтийг гаргасан зэрэг зөрчил илэрлээ.

1.5¹² комиссын бүрэлдэхүүнд эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн бодлого, хэрэгжилт, зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий төрийн захиргааны болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх комисс 9-11, Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх комисс 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байна.

1.6¹³ Комиссын бүрэлдэхүүнийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр томилж чөлөөлнө. Эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх комиссын даргыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх комиссын даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга томилно. Нарийн бичгийн даргыг ажлын алба томилно.

4.2¹⁴ Шинжээчийг сонгон шалгаруулахад дараах шалгуурыг үндэслэнэ.

4.2.1 Мэргэжлийн болон эрдмийн зэрэг цолтой;

4.2.2 Холбогдох мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажиллаж мэргэшсэн, байгууллагын удирдлага, зохион байгуулалтаар ажлын дадлага, туршлагатай;

4.2.3 Эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллах чадвартай;

4.2.4 Тусгай зөвшөөрлийн шаардлагын талаар мэдлэгтэй;

4.2.5 Ашиг сонирхлын зөрчилгүй байх;

4.2.6 Гэмт хэрэгт холбогдож байгаагүй;

4.3.2¹⁵ Сонгон шалгаруулалтыг ажлын албанаас 4.2-т заасан шалгуурын дагуу үнэлгээний шалгуур хангасан шинжээчийг комиссын хурлаар хэлэлцүүлж сонгон шалгаруулж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр баталгаажуулж, 2 хүртэлх жилийн хугацаатай гэрээ байгуулж, шинжээчийн эрхийн үнэмлэх олгоно.

1.7¹⁶ Комисс нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчдийг татан оролцуулах ба шинжээчийг сонгон шалгаруулж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр 2 хүртэл жилийн хугацаатай томилно.

Аудитын хугацаанд Цагаанчулуут, Цэцэн-Уул Шилүүстэй, Ургамал, Идэр, Цагаанхайрхан, Дөрвөлжин, Сонгино, Сантмаргаз сумдын эмийн эргэлтийн сангууд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулсан бөгөөд сумдын эмийн эргэлтийн сан нь бие даасан хуулийн этгээд биш боловч тусгай зөвшөөрлийг сунгаж, зарим эмийн эргэлтийн сангууд аж ахуйн нэгж байгуулсан боловч тусгай зөвшөөрлийг тус аж ахуйн нэгжийн нэрээр олгоогүй байна. Үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ шинээр гаргуулахаар хүсэлтээ ирүүлсэн Уламжлалт анагаах ухааны төв, Түдэвтэй сум дундын эмнэлэг, Шилүүстэй сумын сум дундын эмнэлэг, Сонгино сумын Эрүүл мэндийн төв, Отгон сумын Эрүүл мэндийн төв, Ургамал сумын Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагуудын Улсын бүртгэлийн гэрчилгээ дээр өөрчлөгдсөн үйл ажиллагааны чиглэлээ бүртгүүлээгүй байна.

Мөн тусгай зөвшөөрлийн комисс, ажлын алба үйл ажиллагааны төлөвлөгөө, хурлаар хэлэлцэх асуудлаа журмын дагуу боловсруулан баталдаг боловч биелэлтийн тайлан гаргадаггүй, хурлаар хэлэлцсэн асуудлаа хурлын тэмдэглэлд тодорхой тусгадаггүй, архивын баримт эмх цэгцгүй байна.

Шинээр тусгай зөвшөөрөл хүссэн болон тусгай зөвшөөрлөө сэргээлгэхээр хүсэлтээ ирүүлсэн байгууллагуудад шинжээчийн баг ажиллуулдаг бөгөөд шинжээчийн дүгнэлт гаргаснаас 1-2 сарын дараа комисс хуралдаж, шийдвэр гаргаж байна. Энэ нь “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ын 6.1.5²¹ дэх заалттай нийцэхгүй байна. Эндээс дүгнэхэд тусгай зөвшөөрлийн комисс журамд заасан хугацааг мөрдөж ажиллахгүй байна. ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн комиссын шийдвэр гарснаас хойш 1 сар, зарим тохиолдолд 1 сар гаруйн хугацааны дараа тусгай зөвшөөрөл олгох шийдвэр буюу Засаг даргын захирамж гарч байна. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.13²² дахь заалттай нийцэхгүй байна. Эндээс дүгнэхэд эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл явц удаашралтай байна.



Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл явц хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна

2019 онд Дөрвөлжин сумын суурь боловсрол эзэмшүүлэх ерөнхий боловсролын сургуулийг бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх ерөнхий боловсролын сургууль болгон шинэчлэн байгуулахаар, 2020 онд Тосонцэнгэл сумын Улаан толгой багт улсын 6 дугаар цэцэрлэгийг, Улиастай сумын Богдын гол багт “Этүгэний энх үрс” хувийн өмчийн цэцэрлэгийг шинээр байгуулахаар тусгай зөвшөөрлийг тус тус олгожээ.

Дээрх 3 байгууллагад сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо Боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2²³-д заасны дагуу боловсролын сургалтын байгууллага байгуулах үндэслэл, тооцоолол байхгүй, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1²⁴, Боловсрол, соёл, шинжлэх ухаан сайдын 2010 оны 353 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага”-ын 2.8.2²⁵-т заасны дагуу сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраар хянуулж, дүгнэлт гаргуулаагүй байна.

Тосонцэнгэл сумын 6 дугаар цэцэрлэг тусгай зөвшөөрөл хүсэж материалаа ирүүлсэн боловч бүрдүүлсэн материал хангалтгүй, Боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1²⁶, 22 дугаар зүйлийн 22.2²⁷ дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан сайдын 2010 оны 353 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэх тусгай

зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага"-ын дагуу бүрдүүлээгүй, Дөрвөлжин сумын суурь боловсролын сургууль, Улиастай сумын "Этүгэний энх үрс" хувийн өмчийн цэцэрлэг холбогдох хууль, журамд заасан баримт материалыг бүрдүүлж өгөөгүй, холбогдох мэргэжилтнүүд хяналт тавьж ажиллаагүй байна. Эндээс дүгнэхэд сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл явц хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй, хангалтгүй түвшинд байна.

6.1.5²² Шинжээчдийн дүгнэлт ирснээс хойш ажлын 10 хоногт багтаан тусгай зөвшөөрлийн комиссын хурлаар дүгнэлтийг хэлэлцүүлнэ.

21.1.2²³ боловсролын сургалтын байгууллага байгуулах үндэслэл, тооцоо бүхий танилцуулга;

20.1²⁴ Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.7.1, 15.7.2, 15.7.4, 15.7.8, 15.7.9, 16.2.4, 16.3.3-д заасны дагуу их сургууль, дээд сургууль, коллежид, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт аймаг, нийслэлийн боловсролын газрын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус олгоно.

2.8.2²⁵ Улсын хэмжээнд үйлчлэх болон гадаадын хөрөнгө оруулалттай сургалтын байгууллага сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг Боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагаар, өмчийн бусад хэлбэрийн сургалтын байгууллага аймаг, нийслэлийн Боловсролын газраар тус тус хянуулж, дүгнэлт гаргуулсан байна.

21.1²⁶ Боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулагч нь тусгай зөвшөөрөл авахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараах баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эхлэхээс зургаагаас доошгүй сарын өмнө тусгай зөвшөөрөл олгох байгууллагад ирүүлнэ:

21.1.1.боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, өргөдөл, дүрэм, үүсгэн байгуулах тухай гэрээний аль нэг;

21.1.2.боловсролын сургалтын байгууллага байгуулах үндэслэл, тооцоо бүхий танилцуулга;

21.1.3.сургалтын төлөвлөгөө;

21.1.4.багшлах боловсон хүчний хангамж, бүрэлдэхүүн, боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа;

21.1.5.сургалт явуулах барилга байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг зэрэг сургалтын хэрэглэгдэхүүний баталгаа;

21.1.6.санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа;

21.1.7.үүсгэн байгуулагчаас сургалтын байгууллагын мэдэлд шилжүүлэх хөрөнгө /биет болон мөнгөн/-ийн жагсаалт, хэмжээ, баталгаа;

21.1.8.байгууллагын эзэмшил газрын зөвшөөрөл.

22.2²⁷ Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах журмаар олгоно:

22.2.1.тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага энэ хуулийн 21.1-д заасан баримт бичгийг үүсгэн байгуулагчаас хүлээн авснаас хойш ажлын 21 өдрийн дотор боловсролын сургалтын байгууллага байгуулах урьдчилсан зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх;

22.2.2.урьдчилсан зөвшөөрөл олгох тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан өдрөөс үүсгэн байгуулагч тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангах талаар санал болгосон нөхцөлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

22.2.3.үүсгэн байгуулагч тусгай зөвшөөрлийн шаардлагыг бүрэн хангасны дараа холбогдох баримт бичгийг өргөдлийн хамт эрх бүхий байгууллагад ирүүлэх;

22.2.4.тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор эрх бүхий байгууллага төрийн захиргааны болон боловсролын байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий шинжээчийн хэсэг томилж, магадлан шинжилгээ хийлгэх бөгөөд магадлан шинжилгээ хийлгэхтэй холбогдсон зардлыг үүсгэн байгуулагч хариуцах;

22.2.5.шинжээчийн хэсэг томилогдсоноосоо хойш 30 хоногт багтаан баримт бичигт магадлан шинжилгээ хийж, газар дээр нь танилцан дүгнэлт гаргах;

22.2.6.энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан байгууллага шинжээчийн хэсгийн дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар шийдвэр гаргаж, үүсгэн байгуулагчид мэдэгдэх, тусгай зөвшөөрлийг олгох.

Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг нэр төрлөөр нь задлан авч үзвэл:



99.7% Хураамж

2019, 2020 онд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжид 66,500.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 66,300.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, аймгийн ИТХ-ын баталсан тэмдэгтийн хураамжийн хэмжээг баримтлаагүйгээс 400.0 мянган төгрөгийг 4 ААНБ-аас илүү, 1 ААНБ-аас 200.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Дутуу төвлөрүүлсэн 200.0 мянган төгрөгийг аудитын явцад төлүүлж, төлбөр төлсөн баримтыг хавсаргав.



86.5% Хураамж

Тамхи худалдах тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж нийт 16,350.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 86.5 хувь буюу 14,150.0 мянган төгрөг орон нутгийн тэмдэгтийн хураамжийн дансанд төвлөрсөн байна. Дутуу төвлөрсөн 2,200.0 мянган төгрөгөөс аудитын явцад 450.0 мянган төгрөгийг төлүүлж, үлдэгдэл 1,750.0 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.



98.1% Хураамж

ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлөөс 2019, 2020 онд 6,260.0 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамж төвлөрөхөөс 98.1 хувь буюу 6,140.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Дутуу төвлөрүүлсэн 1 байгууллагын 120.0 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

ЭМС-ын 2015 оны 298 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ын 1.8²⁸ дахь заалтын дагуу тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн орлого аймгийн Эрүүл мэндийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрч, шинжээчийн хөлс, тусгай зөвшөөрлийн комиссын үйл ажиллагаанд зарцуулагддаг бөгөөд тэмдэгтийн хураамжийн орлогын 2019 оны зарцуулалтыг шалгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу, тусгай зөвшөөрлийн комиссын үйл ажиллагааны зардлын жишигт тусгагдаагүй бичиг хэргийн зардалд 122.0 мянган төгрөг зарцуулсан, оны эцэст 940.0 мянган төгрөгийг НИК рүү шилжүүлж, талон болгосон, 2020 онд мөн 300.0 мянган төгрөгийг НИК рүү шилжүүлж, талон болгосон байна. 2019 оны үлдэгдэл 502.5 мянган төгрөгийг Татварын ерөнхий хуулийн 7.2²⁹, 7.2.9³⁰, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6³¹, 23.6.8³², Улсын тэмдэгтийн тухай хуулийн 42.3³³ заалтын дагуу орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх ёстой боловч Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна. Иймээс аймгийн Эрүүл мэндийн газарт ЭМЧҮАЭ тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн орлогыг журмын дагуу зарцуулж, үлдэгдлийг аймгийн тэмдэгтийн хураамжийн дансанд төвлөрүүлж байх талаар зөвлөмж өгөхөөр, зориулалт бус зарцуулсан 502.5 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

1.8²⁸ Эрүүл мэндийн тухай хуулийн 19.4 дахь заалтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн үйлчилгээний зардлын жишгийг энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан хэмжээгээр Эрүүл мэнд, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын төсөвт бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлын эдийн засгийн ангиллаар улсын төсөвт төсөвлөж, тусгай зөвшөөрлөөс олох орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогод тус тус төсөвлөнө.

7.2²⁹ Монгол Улсын татвар нь доор дурдсан төрөлтэй байна:

7.2.9³⁰ Улсын тэмдэгтийн хураамж;

23.6³¹ Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

23.6.8³² Энэ хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж.

42.3³³ Тэмдэгтийн хураамжийн орлогыг улсын болон орон нутгийн төсвийн дансанд тушаах бөгөөд бэлнээр хураасан орлогын хэмжээ 10 000 төгрөг хүрсэн тухай бүрд дансанд тушааж байна.



0% Хураамж

Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1³⁴, 5.1.24³⁵, 35 дугаар зүйлийн 35.1³⁶, 35.1.3³⁷-д заасны дагуу төвлөрүүлэх ёстой ч тусгай зөвшөөрөл олгосон 3 байгууллагын нийт 750.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй байна. Улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй, үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа Тосонцэнгэл сумын 6 дугаар цэцэрлэгт 250.0 төгрөгийн төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.



0% Хураамж

Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл 2019, 2020 онд олгогдоогүй, Яруу сумын “Улаан эрэг” нэртэй газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Яруу мандал” хоршооны тусгай зөвшөөрлийг 2019.03.06-ны өдрийн аймгийн Засаг даргын А/70 дугаар захирамжаар хүчингүй болгосон байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3³⁸-т заасны дагуу аймгийн ИТХ-ын 2018 оны 43 дугаар тогтоолоор “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-д тусгай зөвшөөрөл хүсэгчийн бүрдүүлэх баримт бичигт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг нэмж оруулах нь зүйтэй байна.

Аймаг, сумын Засаг даргын захирамжаар олгосон тусгай зөвшөөрлөөс түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлөөс бусад 4 төрлийн тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн нийт 89,860.0 мянган төгрөгийн орлого төвлөрөхөөс 96.3 хувь буюу 86,590.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, 3.7 хувь буюу 3,270.0 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. Дутуу төвлөрүүлсэн 3,270.0 мянган төгрөгийн орлогоос аудитын явцад 650.0 мянган төгрөгийг төлүүлж, 2,120.0 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ. Хавсралт № 6-д харуулав.

Дээрх зөрчлүүд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4³⁹, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1⁴⁰ дэх заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна. Иймд тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох хууль, журамд заасан баримтын бүрдэл дутуу, шаардлага хангаагүй аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгохгүй байх, тэмдэгтийн хураамжийг хууль журмын дагуу хурааж, тайланг хуулийн хугацаанд гарган, Татварын хэлтэст хүргүүлж, тооцоо нийлэн ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

5.1³⁴ Тэмдэгтийн хураамжийг дор дурдсан үйлчилгээнд хураана

5.1.24³⁵ Боловсролын тухай хуулийн 20.1-д заасан тусгай зөвшөөрөл олгох;

35.1³⁶ Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

35.1.3³⁷ ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрлийг олгоход 150 000-250 000 төгрөг;

4.3³⁸ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг авсны үндсэн дээр батална. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.

11.1.4³⁹ улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

43.1⁴⁰ Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тэмдэгтийн хураамжийн тайланг хагас, бүтэн жилээр гаргах бөгөөд хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд гаргаж өгнө.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГААС ОЛГОСОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ТАВИХ ХЯНАЛТЫН ҮР ДҮН МУУ БАЙНА.

2.1 Түүвэрт хамрагдсан 4 сумын 4 төрлийн тусгай зөвшөөрөлтэй 97 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шалгахад 51.5 хувьд буюу 50 байгууллагад зөрчил илэрлээ.

Аудитаар Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн, Улиастай сумдын согтууруулах ундаа худалдах, тамхи худалдах, ЭМЧМҮАЭ болон сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 97 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцлаа. Бусад 20 сумдын хувьд холбогдох баримт материалыг гаргуулан авч, судалгааны түвшинд аудитыг гүйцэтгэлээ. Үйл ажиллагаатай танилцсан 97 аж ахуйн нэгж, байгууллагын 39.1 хувь буюу 38 нь согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага байна. *График-3*



13.2% | Импортын согтууруулах ундаа худалддаг

Түүвэрт хамрагдсан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 4 нь тохирлын гэрчилгээгүй, 8 нь тохирлын гэрчилгээний хугацаа дууссан, 30 нь кассын машин ашиглаагүй байна. Шалгалтад хамрагдсан 38 ААНБ-ын 13.2 хувь буюу 5 ААНБ импортын архи, согтууруулах ундаа худалдаж байгаа боловч гаалийн шинжилгээний бичиггүй байлаа.

2019 онд аймгийн Засаг даргын “Цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох тухай” А/291 дүгээр захирамжаар цагийн хязгаарыг баталжээ.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих” журамд импортын архи, согтууруулах ундааны гаалийн шинжилгээний бичгийг бүрдүүлж ажиллах талаар нэмж тусгах шаардлагатай байна.



Тусгай зөвшөөрөлгүй 71 цэг тамхи худалдаалж байна

Их-Уул суманд 1 ААНБ, Тосонцэнгэл суманд 5 иргэн, ААНБ, нийт 6 цэг тамхи худалдах зөвшөөрлийн хугацаа дууссан боловч үйл ажиллагаа явуулж байсан зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Хугацаа дууссан тамхи худалдаж байсан 5 цэгийг илрүүлж, тамхийг хураан Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч нарт хүлээлгэн өглөө.

Сумын Засаг даргаас олгож буй тамхи худалдах тусгай зөвшөөрөлд доорх нийтлэг алдаа гарч байна. Үүнд:

- Сонгино суманд 2018 оны 10 сарын 25-ны өдрийн А/44 дүгээр захирамжийг үндэслэн 9 аж ахуйн нэгж, иргэний тусгай зөвшөөрлийн хугацааг дахин сунгаж, гэрчилгээ олгосон.

- Тосонцэнгэл, Улиастай суманд тамхины зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийг түүвэрчлэн шалгахад тусгай зөвшөөрлийн гэрчилгээ дээрх захирамжийн дугаар зөрүүтэй, тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргахдаа хүсэлт өгсөн хугацааг харгалзалгүй өмнөх зөвшөөрөл дууссан хугацааг оруулан сунгалтыг хийж байна.
- Цагаанчулуут, Нөмрөг сумдын Засаг даргаас ирүүлсэн албан бичгээр 2019, 2020 онд тамхины тусгай зөвшөөрөл олгоогүй гэсэн боловч 2019 онд 2 захирамжаар 2 аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгосон нь аудитын явцад илэрлээ.
- Баянтэс, Идэр сумдад тамхины тусгай зөвшөөрөлтэй тамхи худалдаж буй тус бүр 1 цэг байгаа боловч 2013 оноос хойш тусгай зөвшөөрлөө сунгуулаагүй, үйл ажиллагаагаа явуулж байна.
- Тэлмэн сумын Нуур багт худалдаа үйлчилгээний цэг ажиллуулж байгаад үйл ажиллагаа зогссон байхад захирамж гаргаж, тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгосон байна. Иргэн Д.Нямдорж нь тусгай зөвшөөрөл гарснаас хойш үйл ажиллагаа явуулаагүй учраас тэмдэгтийн хураамж 100.0 мянган төгрөгийг төлөхгүй гэсэн тайлбарыг ирүүлсэн.
- Тэс сумын ЗДТГ-ын ХАА-н тасгийн ХЖДҮХ мэргэжилтэн нь 2 аж ахуйн нэгжийн тэмдэгтийн хураамж 300.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэлгүй, хувьдаа авсан нь аудитын явцад илэрлээ.
- Дөрвөлжин сумын “Хомын тал” ХХК нь “Баян-айраг эксплорэйшн” компанийн кемпэд тамхи худалдаалахаар тусгай зөвшөөрөл гаргуулсан боловч 2020 оны 01 сард Хэрлэн дэлгүүрийг худалдсан, одоо сумын төвд ажиллаж байгаа байршил нь “сургуулийн хичээлийн болон дотуур байртай 500 м дотор учраас тамхи худалдаалахгүй тул тэмдэгтийн хураамж 150.0 мянган төгрөгийг төлөх боломжгүй байна” гэсэн тайлбар ирүүлсэн.
- Аймгийн Цагдаагийн газраас гаргуулсан судалгаагаар Баянхайрхан, Завханмандал, Их-Уул, Нөмрөг, Отгон, Сантмаргаз, Тэлмэн, Тэс, Ургамал, Цэцэн-Уул, Шилүүстэй сумдад 71 цэг тусгай зөвшөөрөлгүй тамхи худалдаалж байна.

Тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа зөрчил илэрсэн нь Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна. Иймд сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд Тамхины хяналтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1⁴¹-д заасны дагуу хяналтыг үр дүнтэй хийж, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.



Түүвэрлэн шалгасан ~~ЭМЧИМЭЭ~~
тусгай зөвшөөрөлтэй байгууллагууд
үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна

нийт 18 байгууллагыг түүвэрлэн үйл ажиллагаатай танилцлаа.

Аудитын явцад Улиастай суманд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 4 хувийн эмийн сан, 6 хувийн эмнэлэг, 1 ариутгал халдваргүйтгэлийн үйлчилгээ, Тосонцэнгэл суманд үйл ажиллагаа эрхлэх 1 хувийн эмнэлэг, 2 хувийн эмийн сан, Нэгдсэн эмнэлэг, Их-Уул суманд үйл ажиллагаа эрхлэх 2 хувийн эмийн сан, Тэлмэн суманд үйл ажиллагаа эрхлэх 1 хувийн эмийн сан,

Түүвэрт хамрагдсан тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. “Сод индэрт” ХХК-ийн “Төгс жаргалан” үүдэн эмнэлэг, “Баясгаланг хурахуй” шүдний эмнэлэг, “Пүнзэт хангай” ХХК-ийн “Гурван-Эрдэнэ” эмийн сан, “Наран очир хайрхан” хувийн эмнэлэг 2020 онд санхүүгийн тайлан гаргаагүй, мөн шинээр үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллага Нягтлан

бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1⁴² дэх заалтын дагуу харьяа санхүүгийн байгууллагад бүртгүүлж, санхүүгийн тайлангаа цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй бөгөөд “Жавцаг мед” үүдэн эмнэлэг, “Гоо энэрэл” эмэгтэйчүүдийн үүдэн эмнэлэг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст бүртгүүлээгүй, санхүүгийн тайлан гаргаагүй байна. Мөн “Хан түшиг уянга” эмийн сангийн 1 жор баригч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа дууссан боловч ажиллаж байсан бөгөөд “лицензээ сунгуулахаар Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүсэлтээ өгсөн, хөгжлийн төвөөс лицензээ аваагүй” гэсэн тайлбарыг өгч байсан.



Дөрвөлжин сумын сургууль үйл ажиллагаагаа одоог хүртэл өөрчлөөгүй, эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоогүй байна.

2019, 2020 онд тусгай зөвшөөрөл олгосон 3 байгууллагаас Тосонцэнгэл сумын 6 дугаар цэцэрлэг аймгийн Засаг даргын 2020 оны 01 сарын 10-ны өдрийн А/14 дүгээр захирамжаар шинээр байгуулагдаж, тусгай зөвшөөрлөө авсан бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. “Этүгэний энх үрс” хувийн цэцэрлэг аймгийн Засаг даргын 2020 оны 10 сарын 08-ны өдрийн А/374 дүгээр захирамжаар шинээр байгуулагдаж, тусгай

зөвшөөрлөө авсан бөгөөд 2020 оны 10 сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн боловч ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоосонтой холбогдуулан үйл ажиллагаа нь зогсонги байдалд орж, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрийн хүсэлтээр аймгийн Засаг даргын 2021 оны 09 сарын 17-ны өдрийн А/338 дугаар захирамжаар тусгай зөвшөөрлийг цуцалсан байна. Харин аймгийн Засаг даргын 2019 оны 10 сарын 03-ны өдрийн А/304 дүгээр захирамжаар Дөрвөлжин сумын суурь боловсрол эзэмшүүлэх ерөнхий боловсролын сургуулийг бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх ерөнхий боловсролын сургууль болгон шинэчлэн байгуулахаар шийдвэрлэсэн боловч одоог хүртэл бүрэн дунд сургууль болж өөрчлөгдөөгүй бөгөөд суурь боловсрол эзэмшүүлэх 2018 оны 09 сарын 05-ны өдрийн 0002770 тоот, 05 бүртгэлийн дугаар бүхий сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцсон байна. Шийдвэр гаргасан эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрлийг олгосноос хойш 2 жилийн хугацаа өнгөрсөн боловч тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоогүй байна. Энэ нь Боловсролын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1⁴³, 24.1.3⁴⁴ дахь заалтыг зөрчиж байна.

11.1⁴¹ Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.

9.1⁴² Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй.

24.1⁴³ Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1-д зааснаас гадна дараах үндэслэлээр түүнийг хүчингүй болгоно:

24.1.3⁴⁴ улсын бүртгэлд бүртгүүлсэн буюу тусгай зөвшөөрөл авснаас хойш зургаан сарын дотор үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй

2.2. Тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллагуудын хяналтын үр дүн муу байна.



Хяналт хийгдэж байгаа ч
үр дүн гарахгүй байна

МХЕГ-ын 2019 оны 01/04 тоот удирдамжийн дагуу сар шинийн баярыг угтан аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2019.02.28-ны өдрийн 01/04 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн тухай хяналт шалгалтын танилцуулгаар Завхан аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газар, Онцгой байдлын газар, Улиастай сумын ЗДТГ, багийн засаг дарга нартай хамтран, тус газрын хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, харилцаа, холбоо, хэмжилзүйн хэлтсийн улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2019.01.15-аас 2019.02.08-ны өдрүүдэд шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Тус шалгалтад 166 ААНБ, 57 иргэнийг хамруулж, давхардсан тоогоор 908 зөрчил илрүүлж, 642 зөрчлийг газар дээр нь арилгуулж, гүйцэтгэлийн хяналтыг 18 ААНБ, иргэдэд хийж, улсын хил нэвтрүүлэх журам зөрчиж импортолсон 22 нэр төрлийн 1,731.0 мянган төгрөгийн согтууруулах ундааг Улиастай сумын Засаг даргын дэргэдэх “Хураагдсан эд зүйлийг шийдвэрлэх орон тооны бус зөвлөл”-д шилжүүлэн шийдвэрлүүлж, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлсэн гэсэн боловч аудитын явцад нотлох баримтыг хангалттай ирүүлээгүй болно.

Аймгийн МХГ-ын 2019.05.28-ны өдрийн 07/263 дугаартай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг цуцлуулах 12 аж ахуйн нэгжийн саналыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн боловч хариу тоот хүргүүлээгүй, жагсаалтад байгаа аж ахуйн нэгжээс 2 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрөл цуцлагдсан байна.

Аймгийн МХГ-аас 2019.05.31-ний өдрийн 07/273 дугаартай албан бичгээр аймгийн Засаг даргад “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.5⁴⁵, 5 дугаар зүйлийн 5.3⁴⁶ дахь заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай саналыг хүргүүлсэн боловч 2019.06.10-ны өдрийн 1/643 дугаартай албан бичгээр “зөвшөөрөгдсөн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу тогтмол хяналт тавьж тайланг хагас, бүтэн жилээр гарган ирүүлэх” гэсэн хариу өгсөн бөгөөд дээрх албан бичгүүдээс харахад аймгийн Засаг даргад хүргүүлсэн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг цуцлуулах болон хамтран ажиллах саналууд хэрэгжээгүй байна гэж үзлээ.



Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019.09.01-ний өдрийн 01/47 дугаартай шалгалт хийсэн тухай хяналт шалгалтын танилцуулгаар эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч 2019.01.10-ны өдрөөс 2019.08.31-ний өдрүүдэд шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Тус шалгалтад Завхан аймгийн 24 сумын Засаг даргын гаргасан тамхи худалдаалах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 148 цэгээс 13 сумын 98 аж ахуйн нэгж, иргэн хамрагдаж, давхардсан тоогоор 58 зөрчил илрүүлж, 10 буюу 32 хувийг газар дээр нь арилгуулж, илэрсэн зөрчилд холбогдуулан 23 аж ахуйн нэгж, иргэнд 23 заалт бүхий хугацаатай албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллажээ. Аудитын явцад нотлох баримтыг хангалттай ирүүлээгүй учраас хяналт шалгалтыг хангалтгүй гүйцэтгэж байна гэж үзлээ.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2020.06.12-ны өдрийн 01/37 дугаартай шалгалт хийсэн тухай хяналт шалгалтын танилцуулгаар эрүүл ахуй, халдвар

хамгааллын хяналтын улсын байцаагч 2020.01.10-ны өдрөөс 2020.06.10-ны өдрүүдэд шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-ын 6 дугаар зүйлд заасны дагуу сумын ИТХ-аар үйл ажиллагааны журмаа батлуулж, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд хяналтын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аудитын хугацаанд Асгат, Ургамал, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл “хариуцсан албан тушаалтан чөлөө авсан, холбоо барих боломжгүй, хариуцсан ажилтан албан томилолтоор явсан, эрүүл мэндийн шалтгаанаар чөлөө авсан, баримт материалаа хүлээлгэж өгөлгүй шилжсэн” зэрэг шалтгаанаар ажлын төлөвлөгөө, тайлан, холбогдох материалаа ирүүлэх боломжгүй талаар албан тоотоор мэдэгдсэн. Бусад сумдын тухайд ирүүлсэн материалыг үзэж танилцахад шаардлага хангахгүй байна.



Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд аймгийн Мэргэжлийн хяналтын газраас хяналт шалгалт хийгдсэн гэх боловч аудитын хугацаанд хариуцсан улсын байцаагч холбогдох баримт, материалаа ирүүлээгүй учраас дүгнэх боломжгүй байна.



ЭМЧМҮАЭ комисс
ажлын алба 2020 онд
хяналт хийгээгүй байна

Аймгийн ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн комиссын дэргэдэх ажлын алба /Аймгийн Эрүүл мэндийн газар/ нь 2019 онд ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн комиссын даргын удирдамжаар Тосонцэнгэл сумын 7, Их-Уул сумын 2 хувийн хэвшлийн эмийн сангуудын үйл ажиллагаанд, Улиастай суманд үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлсэн боловч хувийн эмнэлэг, сувиллын үйл ажиллагаанд хяналт хийсэн талаарх тайлан, баримт материал байхгүй. Харин эмийн сангуудын үйл ажиллагаанд хяналт хийж, Улиастай суманд үйл ажиллагаа явуулж байгаа 9 эмийн сангийн хяналтаар илэрсэн зөрчилд зөвлөмж өгч, зөвлөмжийн биелэлтийг тооцож ажиллаагүй байна. Мөн Отгон, Цагаанчулуут, Шилүүстэй сумдад хяналтаар явсан боловч хяналт хийсэн талаарх баримт материал байхгүй байна. 2020 онд ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн комисс, ажлын алба хяналт хийгээгүй байна. Энэ нь журмын 6.2.1⁴⁷, 6.2.2⁴⁸ дахь заалтыг зөрчиж байна.

Мэргэжлийн хяналтын газраас 2019-2020 онд тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллага, мэргэжилтний үйл ажиллагааны Эрүүл ахуй халдвар хамгааллын төлөвлөгөөт хяналт шалгалтад 41, зөвлөн туслах үйлчилгээнд 15, Эмчилгээний чанарын төлөвлөгөөт хяналт шалгалтад 48, зөвлөн туслах үйлчилгээнд 5, Эм био бэлдмэлийн хяналт шалгалтад 43, зөвлөн туслах үйлчилгээнд 5 байгууллагыг хамруулан, нийт 116 байгууллагад хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн байна. Илэрсэн зөрчил дутагдалд 10 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, биелэлтийг хангуулан ажиллажээ.

2020-2021 онд МХЕГ-ын 01/61 удирдамжийн дагуу шинээр тусгай зөвшөөрөл олгосон, хаяг байршил нь өөрчлөгдсөн эрүүл мэндийн байгууллагуудад тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж байгаа байдалд 7 байгууллага, 358 мэргэжилтний тусгай зөвшөөрөлд хяналт шалгалтыг хийж, Эмчилгээний чанарын хяналтаар 250.0 мянган төгрөгийн, Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтаар

300.0 мянган төгрөгийн, Эм био бэлдмэлийн хяналтаар 2 иргэнд 600.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулсан байна.

ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн комисс, ажлын албаны 2021 онд хийсэн хяналтаар 2019 онд шинээр тусгай зөвшөөрөл олгосон Сонгино сумын “Сонгино сант марал” хувийн эмнэлэг, Отгон сумын “Эх тунамал Сувдмаа” ХХК-ийн “Эх тунамал” эмийн сан, 2020 онд шинээр тусгай зөвшөөрөл олгосон “Сонгино Чандмань” эмийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Тусгай зөвшөөрөл олгож байгаа аймаг, сумын Засаг дарга, тухайн салбарын бодлого хариуцсан газар, хэлтэс Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3⁴⁹-т заасан эрхээ хэрэгжүүлж, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавих чиг үүрэгтэй байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн холбогдох арга хэмжээг авч, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.

2.3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэн, аж ахуйн нэгжээс ирсэн өргөдөл, хүсэлтийг бүрэн бүртгэж, шийдвэрлээгүй байна.



Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэн, аж ахуйн нэгжээс 2019, 2020 онд бүртгэлээр 70 өргөдөл, хүсэлт ирснээс 68.6 хувь буюу 48 өргөдлийг шийдвэрлэжээ.



2019, 2020 онд эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах 15, сунгуулах 17, сэргээлгэх 3, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд үйл ажиллагааны чиглэл, нэр, хаяг өөрчлүүлэх хүсэлт 12, нийт 47 өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэж, ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөлд гомдол ирээгүй байна.



2020 онд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 3 өргөдөл ирж, зураг зүйн шүүлтээр давхцал гарсан тул олгогдоогүй байна.

4.1.5⁴⁵ Мэргэжлийн хяналтын байгууллагад бүртгүүлж, эрсдэлийн үнэлгээгээр бага/ $\leq 29\%$ / эрсдэлтэй үнэлэгдсэн байх

5.3⁴⁶ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагад мэдээллээ бүртгүүлсэн тодорхойлолт гаргуулсан байна.

6.2.1⁴⁷ Ажлын алба нь тусгай зөвшөөрөл олгосон эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан чиг уургийн дагуу гүйцэтгэнэ;

6.2.2⁴⁸ Эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор бүтэц, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт хийж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгуулах зөвлөмж өгнө;

10.1.3⁴⁹ тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих;

АУДИТЫН ДҮН

Аудитаар илэрсэн зөрчлийг агуулгаар нь авч үзвэл дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Хууль, журамд заасан баримтын бүрдэл хангаагүй, тэмдэгтийн хураамж төлөөгүй, аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгосон;
- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохдоо нормативыг мөрдөж ажиллаагүй;
- Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгахдаа хяналтгүй олгосон;
- Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг дутуу ногдуулан хураасан;
- Тэмдэгтийн хураамжийн тайланг гарган, Татварын хэлтэст хүргүүлж, тооцоо нийлээгүй;
- Импортын архийг гаалийн шинжилгээний бичиггүй худалдаалсан;
- Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж ажиллаагүй аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох талаар арга хэмжээ аваагүй;
- Тусгай зөвшөөрлийн олголт, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид тавих хяналт хангалтгүй;
- Тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг бүртгэж, шийдвэрлээгүй;
- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн сунгалтыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй;
- Мэдээ, судалгаа, баримт материалыг шаардсан хугацаанд ирүүлээгүй;
- Ирүүлсэн мэдээ, судалгаа нь шаардлага хангаагүй;

Зөрчлийн агуулгаас харахад тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн төрөл тус бүр дээр зөрчил, дутагдал гарсан боловч ихэвчлэн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх болон тамхи худалдах тусгай зөвшөөрлийн олголттой холбоотой зөрчил дутагдал дийлэнх хувийг эзэлж байгаад дүгнэлт хийж, эрх бүхий албан тушаалтнуудад ажил сайжруулах үүрэг даалгавар өгч, зөрчил дутагдлыг бүрэн арилгуулах шаардлагатай гэж үзлээ.

Аудитаар нийт 4,484.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, аудитын явцад 650.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулж, 2,622.5 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоохоор, 1,862.0 мянган төгрөгийн зөрчилд аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл, урлагийн газарт зөвлөмж өгөхөөр, бусад алдаа зөрчилд 6 байгууллагад 26 заалт бүхий зөвлөмж өгөхөөр, Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газарт зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1.1 Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах нормативыг тогтоосон хууль эрх зүйн орчин хангалтгүй байна.

- Аудитаар аймаг, сумын Засаг дарга аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгохдоо хууль, журамд заасан норм, норматив байршлыг мөрдөж ажилласан эсэх талаар шалгахад хэрэгжилт хангалтгүй үзүүлэлттэй байна;
- Норматив хангаж байгаа эсэхийг сумдаар харьцуулахад: Алдархаан, Асгат, Баянтэс, Баянхайрхан, Дөрвөлжин, Идэр, Их-Уул, Нөмрөг, Сантмаргаз, Түдэвтэй, Тэлмэн, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй, Эрдэнэхайрхан, Яруу сумд нормативд хэмжээнд, харин 7 суманд нормативаас 76 цэгт илүү зөвшөөрөл олгосон бөгөөд Тосонцэнгэл, Улиастай сумдад нормативаас 67 цэгт илүү зөвшөөрөл олгосон байна;
- Завханмандал, Отгон, Сонгино, Тосонцэнгэл, Тэс, Улиастай, Ургамал сумдад согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо байвал зохих хэмжээнээс илүү байгаа нь тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтнууд ажилдаа хариуцлагагүй хандаж, мөрдөж байгаа нормативыг хэтрүүлж, хавтгайруулан олгосноос шалтгаалсан байна;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтыг хэрэгжүүлж, ХХААХҮС-ын 2020 оны А-272 дугаар тушаалын 1 дэх заалтыг мөрдөж ажиллах шаардлагатай байна;
- Аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулж, тусгай зөвшөөрөл хүсэгчийн хүсэлтийг, эрх бүхий байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсгээр хэлэлцэн, сонгон шалгаруулалтаар, тогтоосон нормативд багтаан олгох асуудлыг тусгаж өгөх шаардлагатай байна;
- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах талаар судалж, төлөвлөгөөнд оруулах шаардлагатай байна;
- Сумын Засаг дарга нар Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалтыг баримтлан тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгож байгаа боловч хэмжилтийг хийж баримтжуулаагүй байна;
- Шинээр тусгай зөвшөөрөл олгосон байгууллагуудын эрхлэх үйл ажиллагаа нь ЭМС-ын баталсан ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгоход баримтлах тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна;
- ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн комисс журмын 2.1.3-т заасны дагуу орон нутгийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ, шаардлагын судалгаа гаргаж, саналаа боловсруулан холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлээгүй байна;
- ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журмын 2.6.1-д заасны дагуу эрүүл мэнд, эм хангамжийн байгууллага шинээр байгуулах төсөл тэргүүлэх чиглэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодит хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг хэлэлцээгүй, хурлын тэмдэглэлд тодорхой тусгаагүй байна;

1.2 Хууль, журамд заасан баримтын бүрдэл хангаагүй, тэмдэгтийн хураамж төлөөгүй, дутуу төлсөн аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд тусгай зөвшөөрлийг олгосон байна.

- ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл хүсэгчийн баримтын бүрдэл дутуу, бүрдүүлсэн баримт шаардлага хангахгүй, хувийн хэрэг эмх цэгцгүй байна. Тусгай зөвшөөрлийн ажлын алба, шинжээчийн баг баримт бичгийн бүрдүүлэлт, эмх цэгц, бүрдлийг хангуулахад анхаарч ажиллах шаардлагатай байна;
- Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл явц удаашралтай байна;
- Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо боловсролын сургалтын байгууллага байгуулах үндэслэл, тооцоолол байхгүй, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг Боловсрол, соёл урлагийн газраар хянуулж, дүгнэлт гаргуулаагүй байна;
- Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл явц хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна;
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т заасны дагуу аймгийн ИТХ-ын 2018 оны 43 дугаар тогтоолоор “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-д тусгай зөвшөөрөл хүсэгчийн бүрдүүлэх баримт бичигт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг нэмж оруулах нь зүйтэй байна;

2.1 Түүвэрт хамрагдсан 4 сумын 4 төрлийн тусгай зөвшөөрөлтэй 97 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шалгахад 51.5 хувьд буюу 50 байгууллагад зөрчил илэрлээ.

- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 4 нь тохирлын гэрчилгээгүй, 8 нь тохирлын гэрчилгээний хугацаа дууссан, 30 нь кассын машин ашиглаагүй байна;
- Тамхи худалдах тусгай зөвшөөрлийг холбогдох хууль, журмын дагуу олгодоггүй, тусгай зөвшөөрөлтэй цэгүүдийн зөвшөөрлийн хугацааг хянаж, хугацаа дууссан цэгүүдийн судалгааг гаргаж, сунгадаггүй;
- Тамхи худалдах тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг дутуу төвлөрүүлсэн;
- Тосонцэнгэл, Улиастай суманд тамхины зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийг түүвэрчилэн шалгахад тусгай зөвшөөрлийн гэрчилгээн дээрх захирамжийн дугаар зөрүүтэй, тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргахдаа хүсэлт өгсөн хугацааг харгалзалгүй өмнөх зөвшөөрөл дууссан хугацааг оруулан сунгалтыг хийж байна;
- Тамхи худалдах тусгай зөвшөөрөлгүй 11 сумын 71 цэг үйл ажиллагаа явуулж байна. Тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа зөрчил илэрсэн нь Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна;
- Түүвэрт хамрагдсан эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна;
- ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөлтэй 4 аж ахуйн нэгж 2020 онд санхүүгийн тайлан гаргаагүй, шинээр үүсгэн байгуулагдсан ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтын дагуу харьяа санхүүгийн байгууллагад бүртгүүлээгүй, санхүүгийн тайлангаа гаргаагүй, 1 эмийн сангийн жор баригч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа дууссан боловч ажиллаж байна;
- Аймгийн Засаг даргын 2019 оны 10 сарын 03-ны өдрийн А/304 дүгээр захирамжаар Дөрвөлжин сумын суурь боловсрол эзэмшүүлэх ерөнхий боловсролын сургуулийг бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх ерөнхий боловсролын сургууль болгон шинэчлэн байгуулахаар шийдвэрлэсэн боловч одоог хүртэл бүрэн дунд сургууль болж өөрчлөгдөөгүй бөгөөд суурь боловсрол

эзэмшүүлэх 2018 оны 09 сарын 05-ны өдрийн 0002770 тоот, 05 бүртгэлийн дугаар бүхий сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцсон байна;

- Шийдвэр гаргасан эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрлийг олгосноос хойш 2 жилийн хугацаа өнгөрсөн боловч тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоогүй байна. Энэ нь Боловсролын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3 дахь заалтыг зөрчиж байна;

2.2. Тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллагуудын хяналтын үр дүн муу байна.

- МХГ-аас 2019 онд аймгийн Засаг даргад хүргүүлсэн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг цуцлуулах болон хамтран ажиллах саналууд хэрэгжээгүй байна;
- Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа Тамхины хяналтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу хяналтыг хэрэгжүүлээгүй байна;
- Сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-ын 6 дугаар зүйлд заасны дагуу сумын ИТХ-аар үйл ажиллагааны журмаа батлуулж, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд хяналтын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.
- Асгат, Ургамал, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл ажлын төлөвлөгөө, тайлан, холбогдох материалаа ирүүлээгүй, бусад сумдын тухайд ирүүлсэн материалыг үзэж танилцахад шаардлага хангахгүй байна.
- 2019 онд Отгон, Цагаанчулуут, Шилүүстэй сумдын эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналтаар явсан боловч хяналт хийсэн талаарх баримт материал байхгүй байна;
- 2020 онд ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн комисс, ажлын алба хяналт хийгээгүй байна. Энэ нь журмын 6.2.1, 6.2.2 дахь заалтыг зөрчиж байна;
- Тусгай зөвшөөрөл олгож байгаа аймаг, сумын Засаг дарга, тухайн салбарын бодлого хариуцсан газар, хэлтэс Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т заасан эрхээ хэрэгжүүлж, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавих чиг үүрэгтэй байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн холбогдох арга хэмжээг авч, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.

2.3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэн, аж ахуйн нэгжээс ирсэн өргөдөл, хүсэлтийг бүрэн бүртгэж, шийдвэрлээгүй байна.

- Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэн, аж ахуйн нэгжээс 2019, 2020 онд бүртгэлээр 70 өргөдөл, хүсэлт ирснээс 68.6 хувь буюу 48 өргөдлийг шийдвэрлэсэн байна.

ДҮГНЭЛТ: АЙМГИЙН ХЭМЖЭЭНД СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ЦЭГ САЛБАРЫН ТООГ БУУРУУЛАХ ТАЛААР ҮР ДҮНД ХҮРСЭН АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-ын дарга Ц.Улам-Оргих танаа

1. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т заасны дагуу аймгийн ИТХ-ын 2018 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-д импортын архи, согтууруулах ундааны гаалийн шинжилгээний бичгийг бүрдүүлж ажиллах, тусгай зөвшөөрөл хүсэгчийн хүсэлтийг эрх бүхий байгууллагын төлөөлөл оролцсон ажлын хэсгээр хэлэлцэж, сонгон шалгаруулалтаар, тогтоосон нормативд багтаан олгох талаар, мөн тусгай зөвшөөрөл хүсэгчийн бүрдүүлэх баримт бичигт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг нэмж оруулах;

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал танаа

1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-272 дугаар тушаалын 1-д заасан нормативыг мөрдөж ажиллах;
2. Нормативаас илүү олгосон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх 7 сумын 76 тусгай зөвшөөрлийг дахин судалж шийдвэрлэх;
3. Дөрвөлжин сумын ерөнхий боловсролын сургуулийг бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх ерөнхий боловсролын сургууль болгон шинэчлэн байгуулахаар шийдвэрлэсэн захирамжийг цуцалж, суурь боловсрол эзэмшүүлэх тусгай зөвшөөрлийг сэргээх;
4. Холбогдох хууль, журамд заасан баримтын бүрдэл дутуу, шаардлага хангаагүй аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгохгүй байх;
5. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт тавих ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн холбогдох арга хэмжээг авч, үр дүнг тооцож ажиллах;
6. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн тусгай зөвшөөрөлтэй холбоотой санал хүсэлт, өргөдөл, гомдлыг албан хэрэг хөтлөлтийн дагуу бүртгэж, хуулийн хугацаанд шийдвэрлэж байх;

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын даргын үүргийг орлон гүйцэтгэгч Д.Бямбацогт-д

1. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн бүрдлийг Боловсролын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Боловсрол, соёл, шинжлэх ухаан сайдын 2010 оны 353 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага”-ын дагуу хангуулж, хяналт тавьж ажиллах;
2. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход Боловсрол, соёл, шинжлэх ухаан сайдын 2010 оны 353 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэх тусгай

- зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага"-ын 2.8.2-т заасны дагуу сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргаж байх;
3. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох болон сунгахад Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, 42.4 дэх заалтын дагуу тэмдэгтийн хураамжийг төвлөрүүлж байгаад хяналт тавих

**Аймгийн Эрүүл мэндийн газар болон
Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийн комисст**

1. Хүн амын эрүүл мэндийн бодит хэрэгцээ, шаардлагад үндэслэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хөдөө алслагдсан байршилд тусламж үйлчилгээг ойртуулсан аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрлийг олгох шийдвэр гаргах талаар анхаарч ажиллах;
2. ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл хүсэгчээс холбогдох баримт бичгийг хууль журмын дагуу бүрдүүлэн авч, шаардлага хангаагүй аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргахгүй байх, тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын хувийн хэрэг, баримт бичгийн эмх цэгцэд анхаарч ажиллах;
3. “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ын 1.7-д заасны дагуу шинжээчийг дахин сонгон шалгаруулах;
4. Тусгай зөвшөөрөлтэй эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлэх;
5. ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөлтэй холбоотой аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг албан хэрэг хөтлөлтийн дагуу бүртгэж, хуулийн хугацаанд шийдвэрлэж байх;
6. ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн орлогыг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдлийг хуулийн дагуу аймгийн тэмдэгтийн хураамжийн дансанд төвлөрүүлж байх;

**Сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлыг зохицуулах салбар зөвлөлд**

1. Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-ын 6 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах;
2. Тамхины хяналтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу хяналтыг үр дүнтэй хийж, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж ажиллах;
3. Салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тайланг архивын нэгж болгож, хадгалах;

Сумдын Засаг дарга нарт

1. Тамхины тусгай зөвшөөрөл олгосон иргэн, аж ахуй нэгж байгууллагын тамхины цэгүүдийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн доторх зайг тодорхойлсон зураглалыг гаргаж баримтжуулах;
2. Тамхи худалдах тусгай зөвшөөрлийг холбогдох хууль, журмын дагуу шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгжид олгож байх;
3. Тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгохдоо баримтын бүрдлийг хангуулж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2012 оны 06 дугаар тогтоолын дагуу улсын тэмдэгтийн хураамжийг төлүүлж байх;
4. Тусгай зөвшөөрөл хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулж, улсын тэмдэгтийн хураамжийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, татварын улсын байцаагчтай тооцоо нийлэх ажлыг тогтмолжуулах;
5. Тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Тамхины хяналтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу хяналтыг үр дүнтэй хийх, холбогдох арга хэмжээг авч ажиллах;
6. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гаргахдаа хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж ажиллах, сунгалтыг хийхдээ шийдвэр гаргасан огноогоор олгох;
7. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн тусгай зөвшөөрөлтэй холбоотой санал хүсэлт, өргөдөл гомдлыг албан хэрэг хөтлөлтийн дагуу бүртгэж, хуулийн хугацаанд шийдвэрлэх;

Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 03 сарын 10-ны өдрийн дотор албан тоотоор ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН АЛБАН ТООТ



ЗАВХАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ

81000 Улиастай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-2211

2021.11.10 № 155
танай _____-ны № _____ т

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль журмын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцав.

Тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй болно.

ДАРГА

Ц.УЛАМ-ОРГИХ

D:/Тоот А5 2023/



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: zavkhan.gov.mn@gmail.com


2021.11.10 № 6/1169
танай _____ -ны № _____ т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагаас ирүүлсэн “Орон нутагт тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль журмын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланд тусгагдсан Архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлийн талаар тайланд тусгах санал байхгүй болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ЦЭРЭНХАНД



Document/Тоот C5

811210874



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: zavkhan.gov.mn@gmail.com

2021.11.10 № 8/1172
танай _____-ны № _____ т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Орон нутагт тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль, журмын хэрэгжилт, үр дүнгийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад “Саналгүй” болохыг үүгээр хүргүүлж байна.

НИЙГМИЙН БОДЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА *А. Шаравжамц* А.ШАРАВЖАМЦ



811210820
D/alban toot A5-2021



**ЗАВХАН АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-22-80

2021. 11. 10. № 1/642
танай 2021. 11. 09 -ны № 1303/797 Т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутагт тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль журмын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд саналгүй байгаа болно.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Э.УНДАРМАА



C:\My Documents-2021_A5\1
0001104



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 1301/А/130

Улиастай

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутагт тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль журмын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс, Боловсрол, соёл урлагийн газарт хүргүүлсүгэй.

3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт албан тоотоор ирүүлэхийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ц.Улам-Оргих, аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга Л.Лхамсүрэн, Боловсрол, соёл урлагийн газрын дарга Д.Бямбацогт, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, сумдын Засаг дарга нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Санхүүгийн аудитын албаны аудитор Г.Чулуунбаатар, гүйцэтгэлийн аудитын албаны аудитор Ц.Оюунсүвд нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА



Desktop/tushaal2021

013010680

**ОРОН НУТАГТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

ХАВСРАЛТУУД

Хавсралт № 1

ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийг үйл ажиллагааны чиглэл, сумдаар харуулсан судалгаа

Д/д	Сумын нэр	Анхан шатны эмнэлэг	2 дахь шатны эмнэлэг	Эмийн эргэлтийн сан	Хувийн эмийн сан	Эм ханган нийлүүлэх төв	Хувийн эмнэлэг	Бусад эмнэлэг	Нийт
1	Алдархаан	1		1					2
2	Асгат	1							1
3	Баянтэс	1		1					2
4	Баянхайрхан	1		1					2
5	Дөрвөлжин	1		1					2
6	Завханмандал		1	1					2
7	Идэр	1		1					2
8	Их-Уул	1		1	2				4
9	Нөмрөг	1		1					2
10	Отгон	1		1	1				3
11	Сантмаргаз	1		1					2
12	Сонгино	1		1	1				4
13	Тосонцэнгэл	1	1		7		2		11
14	Түдэвтэй		1	1					2
15	Тэлмэн	1		1	1				3
16	Тэс	1		1					2
17	Улиастай	2	4		13	3	12	4	37
18	Ургамал	1		1					2
19	Цагаанхайрхан	1		1					2
20	Цагаанчулуут	1		1					2
21	Цэцэн-Уул	1		1					2
22	Шилүүстэй		1	1					2
23	Эрдэнэхайрхан	1		1					2
24	Яруу	1		1					2

**ОРОН НУТАГТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Хавсралт № 2

**Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй
аж ахуй нэгж, байгууллагын тоог сумдаар харуулсан судалгаа**

Д/д	Сумын нэр	Хүн амын тоо	Норматив цэгийн тоо	Одоо байгаа цэгийн тоо	Зөрүү	Архины зөвшөөрөлтэй		Тамхины цэг	
						Үйлчилгээ	Худалдаа	Зөвшөөрөлтэй	Зөвшөөрөлгүй
1	Алдархаан	2913	12	2	10	-	2	-	-
2	Асгат	981	4	3	1	-	3	1	-
3	Баянтэс	2632	11	10	1	-	10	-	-
4	Баянхайрхан	1838	7	5	2	-	5	-	7
5	Дөрвөлжин	2236	9	6	3	1	5	5	-
6	Завханмандал	1110	4	5	-1	-	5	-	5
7	Идэр	2535	10	4	6	1	3	-	-
8	Их-Уул	6446	26	21	5	3	18	-	16
9	Нөмрөг	1888	8	5	3	-	5	2	6
10	Отгон	2635	11	12	-1	-	12	-	12
11	Сантмаргаз	1591	6	3	3	1	2	1	8
12	Сонгино	1561	6	7	-1	-	7	9	-
13	Тосонцэнгэл	9326	37	57	-20	9	48	16	-
14	Түдэвтэй	1908	8	8	0	2	6	11	-
15	Тэс	2905	12	16	-4	1	15	2	5
16	Тэлмэн	2816	11	8	3	3	5	2	6
17	Ургамал	1318	5	7	-2	-	7	-	1
18	Улиастай	16696	67	114	-47	17	97	62	-
19	Цагаанхайрхан	1305	5	4	1	-	4	-	-
20	Цагаанчулуут	1289	5	2	3	-	2	1	-
21	Цэцэн-Уул	1667	7	6	1	1	5	-	4
22	Шилүүстэй	1781	7	2	5	-	2	-	1
23	Эрдэнэхайрхан	1700	7	4	3	1	3	3	-

**ОРОН НУТАГТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

24	Яруу	2011	8	5	3	-	5	6	-
Нийт дүн		73088	293	316	-23	40	276	121	71

Хавсралт № 2

**Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй,
тэмдэгтийн хураамжийн зөрчилтэй аж ахуйн нэгжийн тоо**

Д/д	Сумын нэр	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Объектын нэр	Тусгай зөвшөөрлийн чиглэл	Төлбөл зохих т/хураамж	Төлсөн хураамж	Төлөөгүй хураамж	Төлбөрийн актыг барагдуулсан
1	Улиастай	"Бат-өлзий дэлгэр" ХХК	Өлзий дэлгүүр	Худалдаа	200,000	-	200,000	200,000

**ОРОН НУТАГТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Хавсралт № 3

Тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй иргэдийн тэмдэгтийн хураамжийн тооцоотой иргэдийн судалгаа

д/д	Сумын нэр	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр	Объектын нэр	Тусгай зөвшөөрлийн чиглэл	Төлбөл зохих хураамж	Төлсөн хураамж	Төлөөгүй хураамж	Төлбөрийн актыг барагдуулсан	Үлдэгдэл
1	Асгат	Д.Оюунмандах	Алтанбулаг	дэлгүүр	100,000	-	100,000		100,000
2	Дөрвөлжин	Алтан шаргал нутаг ХХК	Алтан шаргал нутаг	дэлгүүр	150,000	-	150,000		150,000
3	Дөрвөлжин	Алтан говь бүрд ХХК	Алтан говь бүрд	дэлгүүр	150,000	-	150,000	150,000	-
4	Дөрвөлжин		Завхан гол	дэлгүүр	150,000	-	150,000		150,000
5	Дөрвөлжин	Мэнгэт сүлд ХХК	Өлзийсайхан	дэлгүүр	150,000	100,000	50,000		50,000
6	Нөмрөг	Ар шивэртэй хоршоо	Их хайрхан	дэлгүүр	150,000	-	150,000		150,000
7	Нөмрөг	Суурьт толид ХХК	Суурьт	дэлгүүр	150,000	-	150,000		150,000
8	Сантмаргаз	Х.Өөдөс	Тамхины мухлаг	мухлаг	100,000	-	100,000		100,000
9	Сонгино	Ембүү хонгор ХХК	Оргил	дэлгүүр	150,000	100,000	50,000		50,000
10	Сонгино	Мөнх цавдангийн ундарга ХХК	Отгонтэнгэр	дэлгүүр	150,000	100,000	50,000		50,000
11	Сонгино	Олон булаг сайхан ХХК	Олон булаг	дэлгүүр	150,000	-	150,000	150,000	-
12	Түдэвтэй	Ж.Лхүндэвданзан	Жамуух	дэлгүүр	150,000	100,000	50,000		50,000
13	Түдэвтэй	Н.Бямбацогт	Шар нуруу	дэлгүүр	150,000	100,000	50,000		50,000
14	Түдэвтэй	С.Баасансүрэн	Баян-Өндөр	дэлгүүр	150,000	100,000	50,000		50,000
15	Түдэвтэй	Э.Нансалмаа	Хунт нуур	дэлгүүр		100,000			

**ОРОН НУТАГТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

					150,000		50,000		50,000
16	Түдэвтэй	Ш.Буяндэлгэр	Гоё гоё	дэлгүүр	150,000	100,000	50,000		50,000
17	Түдэвтэй	М.Уранчимэг	Эх бөөрөг	дэлгүүр	150,000	100,000	50,000		50,000
18	Тэс	Б.Зоригтбаатар	Дөлгөөн тэс мөрөн	дэлгүүр	150,000	-	150,000		150,000
19	Тэс	Дооно түшиц ХХК	Түшиц	дэлгүүр	150,000	-	150,000	150,000	-
20	Улиастай	Очир бадмаараг ХХК	Чандмань очир	дэлгүүр	150,000	100,000	50,000		50,000
21	Цагаанчулуут	Ц.Хүрэлбаатар	Монгол тамхи со	дэлгүүр	100,000	-	100,000		100,000
22	Эрдэнэхайрхан	Хайрхан худгийн ундарга ХХК	Баялаг хайрхан	дэлгүүр	150,000	100,000	50,000		50,000
23	Эрдэнэхайрхан	Алтан алдар хоршоо	Малчин	дэлгүүр	150,000	100,000	50,000		50,000
24	Яруу	Өргөн дэлгэрэх түмэн ХХК	Нутгийн хишиг	дэлгүүр	150,000	100,000	50,000		50,000
25	Яруу	Уран мандаа хоршоо	Эрдэнэзул	дэлгүүр	150,000	100,000	50,000		50,000
Дүн					3,600,000	1,400,000	2,200,000	450,000	1,750,000

**ОРОН НУТАГТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Хавсралт № 4

ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн тэмдэгтийн хураамжийн судалгаа

Д/д	Сумын нэр	Оноосон нэр	Тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны чиглэл	Төрөл	Тэмдэгтийн хураамж /мян.төг/		
					Төлбөл зохих	Төлсөн	Төлөөгүй
1	Улиастай	"Үе залгамжлагч" шүдний үүдэн эмнэлэг	Нүүр амны өвчний оношилгоо эмчилгээ	Сунгасан	120.0	120.0	-
2	Тосонцэнгэл	"Нандин соёл" үүдэн эмнэлэг	Эмэгтэйчүүдийн эмнэлэг	Сунгасан	120.0	120.0	-
3	Улиастай	"Монос уянга" эмийн сан	Эмийн сан	Сунгасан	110.0	110.0	-
4	Шилүүстэй	Сум дундын эмнэлэг	Анхан шатны тусламж үйлчилгээ	Сунгасан	120.0	120.0	-
5	Улиастай	Тунгийн увидас" эмийн сан	Эмийн сан	Сунгасан	110.0	110.0	-
6	Улиастай	"Үе залгамжлагч элит" сувилал	Сувилал	Сунгасан	120.0		120.0
7	Цагаанхайрхан	Эмийн эргэлтийн сан	Эмийн сан	Сунгасан	130.0	130.0	-
8	Дөрвөлжин	Эмийн эргэлтийн сан	Эмийн сан	Сунгасан	110.0	110.0	-
9	Сонгино	Эмийн эргэлтийн сан	Эмийн сан	Сунгасан	110.0	110.0	-
10	Сантмаргаз	Эрүүл мэндийн төв	Анхан шатны тусламж үйлчилгээ	Сунгасан	120.0	120.0	-
11	Улиастай	"Төгс жаргалан" үүдэн эмнэлэг	Эхо оношилгоо	Шинээр олгосон	420.0	420.0	-
12	Улиастай	"Монос"-ын салбар эмийн сан	Эмийн сан	Шинээр олгосон	130.0	130.0	-
13	Тэлмэн	"Өвөгдий" эмийн сан	Эмийн сан	Шинээр олгосон	130.0	130.0	-

**ОРОН НУТАГТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

14	Улиастай	"Баясгаланг хурахуй" шүдний эмнэлэг	Нүүр амны өвчний оношилгоо эмчилгээ	Шинээр олгосон	420.0	420.0	-
15	Цагаанчулуут	Эмийн эргэлтийн сан	Эмийн сан	Сунгасан	110.0	110.0	-
16	Цэцэн-Уул	Эмийн эргэлтийн сан	Эмийн сан	Сунгасан	110.0	110.0	-
17	Шилүүстэй	Эмийн эргэлтийн сан	Эмийн сан	Сунгасан	110.0	110.0	-
18	Ургамал	Эмийн эргэлтийн сан	Эмийн сан	Сунгасан	130.0	130.0	-
19	Их-Уул	"Элбэг" эмийн сан	Эмийн сан	Шинээр олгосон	130.0	130.0	-
20	Улиастай	"Жавцаг мед" үүдэн эмнэлэг	Дотор, зүрх судасны оношилгоо	Шинээр олгосон	420.0	420.0	-
21	Улиастай	"Гэгээн тус" үүдэн эмнэлэг	Уян дурангийн оношилгоо	Шинээр олгосон	420.0	420.0	-
22	Отгон	"Эх тунамал" эмийн сан	Эмийн сан	Шинээр олгосон	130.0	130.0	-
23	Сонгино	"Сонгино сант марал" үүдэн эмнэлэг	Эхо оношилгоо	Шинээр олгосон	420.0	420.0	-
24	Улиастай	"Монос Завхан" эмийн сан	Эмийн сан	Сунгасан	130.0	130.0	-
25	Тосонцэнгэл	"Наран-очир хайрхан" эмнэлэг	Дотор, элэг, цес, чих, хамар, хоолой, хүүхэд, БЗДХ-ын оношилгоо, эмчилгээ	Шинээр олгосон	420.0	420.0	-
26	Улиастай	"ЦЭСОББ" ХХК	Ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал халдваргүйтгэлийн үйлчилгээ	Шинээр олгосон	70.0	70.0	-
27	Улиастай	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Сунгасан	120.0	120.0	-
28	Идэр	Эмийн эргэлтийн сан	Эмийн сан	Сунгасан	110.0	110.0	-
29	Улиастай	"Гоо энэрэл" үүдэн эмнэлэг	Эмэгтэйчүүдийн эмнэлэг	Шинээр олгосон	420.0	420.0	-
30	Улиастай	"Хепа мед элит" үүдэн эмнэлэг	Хоол боловсруулах эрхтэн, элэгний эмгэгийн урьдчилан сэргийлэлт оношилгоо, эмчилгээ	Шинээр олгосон	420.0	420.0	-

**ОРОН НУТАГТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

31	Сонгино	"Сонгино-Чандмань" эмийн сан	Эмийн сан	Шинээр олгосон	130.0	130.0	-
32	Нөмрөг	"Хонгийн толгой" эмийн сан	Эмийн сан	Шинээр олгосон	110.0	110.0	-
33	Тосонцэнгэл	Нэгдсэн эмнэлэг	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Үйл ажиллагааны чиглэл өөрчлөлт	20.0	20.0	-
34	Улиастай	"Одчим наран" эмнэлэг	Мэдрэлийн эмгэг эмчлэх, эрүүл мэндийн болон лабораторийн үйл ажиллагаа эрхлэх	Үйл ажиллагааны чиглэл өөрчлөлт	20.0	20.0	-
35	Улиастай	"Үе залгамжлагч элит" шүдний эмнэлэг	Шүдний эмнэлэг	Нэр өөрчлөлт	20.0	20.0	-
36	Улиастай	"Монос Улиастай" эм ханган нийлүүлэх төв	Эм ханган нийлүүлэх төв	Нэр өөрчлөлт	20.0	20.0	-
Нийт дүн					6,260.0	6,140.0	120.0

**ОРОН НУТАГТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨЖ БАЙГАА ХУУЛЬ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Хавсралт № 5

Нийт тэмдэгтийн хураамжийн тооцооны судалгаа

мян.төг

№	Тэмдэгтийн хураамжийн төрөл	Нийт төвлөрөх	Нийт төвлөрсөн	Илүү төлсөн	Дутуу төлсөн	Аудитын явцад төлсөн	Төлбөрийн акт
1	Архи, согтууруулах ундаа	66,500.0	66,300.0	400.0	200.0	200.0	-
2	ЭМЧМҮАЭ	6,260.0	6,140.0	140.0	120.0		120.0
3	Тамхи худалдах	16,350.0	14,150.0	50.0	2,200.0	450.0	1,750.0
4	Сургалтын байгууллага байгуулах	750.0			750.0		250.0
Нийт дүн		89,860.0	86,590.0	590.0	3,270.0	650.0	2,120.0